



ОРХОН АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/36

Орхон аймаг

Ёс зүйн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 6 дугаар хэсгийн 6.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын хэмжээнд “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, зөвлөлийн ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нийт албан хаагчдад “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг хэвшүүлэн, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг мөрдлөг болгон ажиллахыг Ёс зүйн зөвлөлийн дарга /Ц.Ганхуяг/-д даалгасугай.

ДАРГА



Ж.БАТ-ӨЛЗИЙ

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
даргын 2019 оны 11 дүгээр сарын 20-ны
өдрийн А/36...дугаар тушаалын I хавсралт



ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ёс зүйн зөвлөлийн дарга: Ц.Ганхуяг-Хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн ажилтан

Гишүүд: Г.Баасансүрэн -Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн

Ч.Жунайдорж - Малчдын болон малын бэлчээр, тэжээл, усан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

О.Нурмаажав -Архив, бичиг хэрэг хариуцсан ажилтан

Тарийн бичгийн дарга: Б.Амаржаргал-Техник хангамж, сургалт сурталчилгаа, хөдөө аж ахуйн ололт нэвтрүүлэлт, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
даргын 2019 оны 11 дүгээр сарын 20...-ны
өдрийн А/36 дугаар тушаалын II хавсралт



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Ёс зүйн зөвлөл нь /цаашид "Зөвлөл" гэх/ "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн хэрэгжилтийг хангуулах, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн гомдол, мэдээллийг хүлээн авч үндэслэлтэй эсэхийг шалган тогтоож тогтоол гаргах, байгууллагын дотоод журамд заасан албан хаагчийн ёс зүйтэй холбоотой заалтын хэрэгжилтийг хангуулахад оршино.
- 1.2. Зөвлөл нь "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", холбогдох хууль тогтоомж болон энэхүү журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 1.3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа тэгш хандах, шударга ёсыг баримтлах, нууцыг хадгалах, араат бус байх зарчмыг баримтална.

Хоёр. Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, эрх үүрэг

- 2.1. Зөвлөл нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.
- 2.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг төрийн албан хаагчдын саналыг үндэслэн томилох эрх бүхий албан тушаалтан гурван жилийн хугацаагаар томилно.
- 2.3. Зөвлөлийн ажиллах журмыг томилох эрх бүхий албан тушаалтан батална.
- 2.4. Зөвлөл нь дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэй байна.
- 2.5. Зөвлөл нь ёс зүйн зөрчил, авилга, ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар хариуцлага хүлээж байгаагүй гишүүдээс бүрдэнэ.
- 2.2. Зөвлөл нь дараах эрх үүрэгтэй. Үүнд:
 - 2.2.1. Төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах
 - 2.2.2. Байгууллагын албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан талаарх өргөдөл, гомдлыг хүлээн авах
 - 2.2.3. Гомдол, мэдээлэлд холбогдох төрийн захиргааны албан хаагч, гомдол мэдээлэл гаргагчтай уулзаж, тэдний тайлбар, саналыг сонсох, холбогдох нотолгоо, материал, баримт бичгийг шаардан авах

22.4. Гомдол, мэдээллээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийн мөрөөр, түүнчлэн өөрийн санаачлагаар болон байгууллагын албан хаагчдаас ирсэн санал, гомдлыг хүлээн авч зөрчлийг шалган тогтоох

22.5. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах, хурлын тэмдэглэл хөтлөх, хурлаас гарсан шийдвэрт гишүүдээр гарын үсэг зуруулж, баталгаажуулах, баримт бичгийг эмхэлж архивын нэгж болгох, зохих байгууллага, хувь хүнд ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийг хүргүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

22.6. Ёс зүйн зөвлөл нь тогтоол гаргана.

23. Ёс зүйн зөвлөлийн гишүүн дараах тохиолдолд гомдол, хүсэлтийг хянан шалгах ажиллагааг явуулж болохгүй.

23.1. Гомдол, хүсэлтийг өөрөө гаргасан бол;

23.2. Тухайн ажилтан, гомдол, хүсэлт гаргасан этгээдтэй эсхүл тэдний гэр бүлийн гишүүдтэй төрөл, садан байвал;

23.3. Өөрөө шууд буюу шууд бусаар уг асуудалд хувийн сонирхолтой гэж үзэх үндэслэл байгаа бол;

24. Хурлын шийдвэр гишүүдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.

Гурав. Ёс зүйн зөрчлийн тухай мэдээллийг хүлээж авах, шалгаж шийдвэрлэх

31. Төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн гомдол, мэдээлэл, эсхүл хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн болон тухайн байгууллагын дотоод хяналтаар илэрсэн мэдээ, баримт нь шалгалт явуулах үндэслэл болно.

32. Гомдол, мэдээлэлд холбогдсон албан хаагч болон гомдол, мэдээлэл гаргагчтай уулзаж, тэдгээрийн тайлбар, саналыг сонсож тэмдэглэл хөтлөх

33. Харьяалах нэгжийн удирдлага, албан хаагчидтай уулзаж, шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулах

34. Мэдээллийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор шалгаж шийдвэрлэнэ.

35. Төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг зөрчсөн нь тогтоогдвол тогтоолыг байгууллагын удирдлагад танилцуулан Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлд хүргүүлнэ.